



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2021 оны 05 сарын 18 өдөр

Дугаар A/87

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гэр хорооллын цэвэр бохир усны шугам сүлжээ (Ховд аймаг Жаргалант сум Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг) ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Т.Дэлгэрсайхан	- Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүдэд:	Д.Батцэнгэл	- Мал эмнэлэгийн газрын дарга
	Т.Бямбатөмөр	- Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Ж.Ганболд	- Иргэний төлөөлөл
Нарийн бичгийн дарга:	Д.Дариймаа	- Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Т.Дэлгэрсайхан/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Д.Дариймаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

02-0431